

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН  
БАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.БАЯРСАЙХАН

“ТОЛГОЙТЫН АВТО ЗАМЫГ АРД АЮУШИЙН ӨРГӨН ЧӨЛӨӨТЭЙ ХОЛБОХ  
АВТО ЗАМ, ГҮҮРЭН БАЙГУУЛАМЖ, ОЛОН ТҮВШНИЙ ОГТЛОЛЦОЛ”-ЫН АЖЛЫН  
ТЕХНИК ТЕХНОЛОГИЙН ХЯНАЛТЫГ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР  
ГҮЙЦЭТГҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар: 240 50 20 36

### Нэг. Үндэслэл

- 1.1. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/234 дүгээр захирамж

### Хоёр. Зорилго

- 2.1. Төслөөр хийгдэх барилгын ажил, инженерийн шугам сүлжээний ажилд тавих техник, технологийн хяналтыг олон улсын жишгээр гүйцэтгэх
- 2.2. Авто зам, замын байгууламж, олон түвшний огтлолцол, нүхэн гарцын барилгын ажлын чанарыг Монгол Улс, олон улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм стандартад нийцүүлэн ажиллах.
- 2.3. Нийслэл Улаанбаатар хотын авто замын ачааллыг бууруулах зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй “Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам, гүүрэн байгууламж, олон түвшний огтлолцол”-ын авто зам, замын байгууламжийн барилгын ажилд тавих технологийн хяналтыг сайжруулах, авто замын барилгын ажлын чанарыг дээшлүүлэх, барилгын ажлуудад батлагдсан зураг, төсөв, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах өдөр тутмын техникийн хяналт хийж төслийн явцын тайлан мэдээг бэлтгэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

### Гурав. Хүрэх үр дүн

- 3.1 Төслийн хүрээнд хийгдэх авто зам, замын байгууламж, олон түвшний огтлолцол, нүхэн гарц, инженерийн шугам сүлжээний барилга угсралтын ажлын явцад өдөр тутмын техникийн хяналт хийх Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэж, ажлын уялдааг хангах, чанар стандартыг мөрдүүлснээр ажлын чанар сайжирна.

### Дөрөв. Хугацаа

- 4.1 Захиалагч болон Зөвлөхийн хооронд байгуулах гэрээнд хугацааг тодорхой тусгах бөгөөд гэрээнд заасан төлбөрт багтаан Зөвлөх үйлчилгээ үзүүлнэ.
- 4.2. Зөвлөхийн хяналтын баг нь авто замын барилгын ажлын үргэлжлэх хугацаанд болон барилгын ажил дууссаны дараа улсын комисс ашиглалтад хүлээн авах хүртэл, мөн баталгаат хугацааны үед тус тус ажиллана.

**Тав. Зөвлөх үйлчилгээний ажлын хамрах хүрээ, хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

- 5.1. Зөвлөх үйлчилгээний хяналтын баг нь Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам, гүүрэн байгууламж, олон түвшний огтлолцлын барилгын ажил, тус ажлын хүрээнд хийгдэх бусад ажлуудыг батлагдсан зураг, төсөв, норм норматив, техникийн баримт бичгийн дагуу хийж байгаа эсэхэд хяналт тавих, зөвлөгөө өгөх, ажлын гүйцэтгэлийг хянан баталгаажуулах, төслийн явцын тайлан мэдээ гаргах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 5.2. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Авто зам, замын байгууламжийн барилгын ажлын техник, технологийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг мөрдөнө ажиллана. Зөвлөх нь замын барилгын ажилд уг журмын хавсралтад заасан жишиг маягыг ашиглана.
- 5.3. Гүйцэтгэгчээр ажлын тодотгосон, нэгдсэн, дэлгэрэнгүй график гаргуулан хянаж, Эрх бүхий этгээдэд танилцуулна. Ажлын графикийг 14 хоног тутамд тодотгож ирүүлнэ.
- 5.4. Гүйцэтгэгчийн ажлын төлөвлөгөө, ажиллах хүч, тоног төхөөрөмжийн төлөвлөгөөг хянаж батлах, Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийн байдлыг шалган, зохих тохиргоо зүгшрүүлэлт хийсэн, ажлын шаардлага хангасан эсэхийг батална.
- 5.5. Гүйцэтгэгчийн зүгээс байгуулах хяналтын лабораторийн шаардлага хангаж буй эсэхийг шалгаж, ашиглах зөвшөөрөл олгож лабораторийн туршилт, шинжилгээний ажилд өдөр тутмын хяналт тавьж, шинжилгээний үр дүнг баталгаажуулж ажиллана.
- 5.6. Гүйцэтгэгчийн чанарын баталгаа, төлөвлөгөөг батална.
- 5.7. Гүйцэтгэгчийн гаргах байгаль орчныг нарийвчилсан үнэлгээг хянан саналаа өгнө.
- 5.8. Гүйцэтгэгчийн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын төлөвлөгөөг хянан баталгаажуулна.
- 5.9. Техникийн шаардлагын дагуу замын далан, хөлдөлтөөс хамгаалах үе, суурийн дээд ба доод үе, хучлагад ашиглагдах материал, элс-хайрган хольц, битум, эрдэс нунтаг, асфальтбетон хольц, цемент, буталсан чулуу, ус, арматур, гүүр, туннелийн болон бусад хийцийн төмөр бетон бүтээц эдлэл,

төмөр бетон хоолой болон бусад материалуудын эх үүсвэрийг баталгаажуулж зөвшөөрөл өгнө.

- 5.10. Замын трассыг улсын геодезийн өндөржилтийн цэгтэй холбох, завсрын өндөржилтүүдийн цэгүүдийг байгуулах, замын тэнхлэгийн шугамыг тавих, гүйцэтгэлийн зураг гаргах зэрэгт хяналт тавин тэдгээрийг баталгаажуулна.
- 5.11. Гүйцэтгэгчийн гаргасан газрын түвшин, төлөвлөсөн түвшин, хөндлөн огтлолын зураг, геодезийн хэмжилтийн үр дүнг шалган баталгаажуулж, ажил гүйцэтгэх зөвшөөрөл өгнө.
- 5.12. Гүйцэтгэгчийн гаргасан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, түр зам барих болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах төлөвлөгөөг гарган хянаж, батална.
- 5.13. Зөвлөх нь ажлын явцад Гүйцэтгэгчийн хийсэн ажлын тоо хэмжээг геодезийн болон бусад хэмжилтийн багаж ашиглан хяналт хийж, тайлан гаргаж Эрх бүхий этгээдэд ирүүлнэ.
- 5.14. Замын далан, хөлдөлтөөс хамгаалах үе, суурийн доод ба дээд үе, хучлагын ажлын технологийн дараалал, өндрийн түвшин, үеийн нягтруулалт, гадаргуугийн хөндлөн хэвгий, тэгш байдлыг өдөр бүр шалгаж дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэх зөвшөөрлийг бичгээр өгч байх.
- 5.15. Төмөрбетон гүүр, туннел, авто зам, хиймэл байгууламж, холбогдох инженерийн шугам сүлжээний ажлыг хянан батлах.
- 5.16. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг олборлох зөвшөөрлийг холбогдох эрх бүхий байгууллагаас авахад Гүйцэтгэгчид дэмжлэг үзүүлнэ.
- 5.17. Замын тэмдэг болон бусад тоноглолыг суулгахаас өмнө зураг төсөл, техникийн шаардлагын дагуу урьдчилан хянаж батална.
- 5.18. Ажил эхлэхээс өмнө ган төмөр, төмөрбетон, асфальтбетон орц материалыг итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулна.
- 5.19. Гүйцэтгэгчийн үйлдвэрлэж байгаа асфальтбетон болон бетон хольцын орц ба чанарт өдөр тутмын хяналт тавина.
- 5.20. Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмж, ажил, ажиллах хүчний даатгалын гэрээг хянах.
- 5.21. Зөвлөх нь батлагдсан ажлын зураг, техникийн шаардлагын дагуу зөвшөөрөгдсөн материал, тоног төхөөрөмж ашиглан ажил гүйцэтгэх технологийн дагуу барилга угсралтын ажлыг явуулж байгаа эсэхэд өдөр тутмын хяналтыг хийж тэмдэглэл хөтөлнө.
- 5.22. Авто зам, замын байгууламжийн барилгын хэрэгжилтэд хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлж буй этгээд нь Авто замын зөвлөх үйлчилгээний техникийн

дүрмийн хоёрдугаар хавсралтад дурдсан жишиг маягтуудыг ашиглан хяналтын үйл ажиллагааг явуулна.

- 5.23. Гүйцэтгэгчийн ажлын зураг, материал, хийц хэсэг, тоног төхөөрөмж, ажлын аргачлал өөрчлөгдөх бүрд Зөвлөх тэдгээрийг хянаж Эрх бүхий этгээд болон Захиалагч байгууллагатай зөвшилцөж зөвшөөрөл олгоно.
- 5.24. Ажлын бус амралтын цагаар болон илүү цагаар гүйцэтгэгч ажиллах хүсэлт гаргавал зөвлөх ажиллах үүрэгтэй.
- 5.25. Барилгын ажлын явцад ажлын зураг, хийц, техникийн шаардлага зөрчих, батлагдаагүй материал, тоног төхөөрөмж ашиглах, батлагдсан аргачлалаас өөр аргаар ажил гүйцэтгэх бүрд Зөвлөх нь Гүйцэтгэгчийн ажлыг зогсоох эрхтэй. Ажил зогсоох шаардлагыг албан бичгээр өгнө.
- 5.26. Зөвлөх нь долоо хоног, сарын эхээр Гүйцэтгэгчтэй хамтран талбайн уулзалт хийх бөгөөд энэ уулзалтаар долоо хоногт болон сард төлөвлөсөн ажлын явц, гүйцэтгэл, ажлын чанар, ажлын графикийн өөрчлөлт зэрэг барилга угсралтын ажлын явцтай холбоотой асуудлуудыг хэлэлцэх ба уулзалт бүрийн тэмдэглэлийг хөтөлж баталгаажуулна. Онцгой нөхцөл байдал үүссэн тухай бүрд уулзалт зохион байгуулж болно.
- 5.27. Зөвлөх нь Эрх бүхий этгээдээр дамжуулан холбогдох байгууллагуудтай албан бичгээр аливаа асуудлыг шийдвэрлэж байна.
- 5.28. Гүйцэтгэгчийн хийсэн ажил нь чанарын шаардлага хангаагүй бол түүнийг дахин хийлгэх, засварлуулах зэрэг арга хэмжээг тухай бүрд авах бөгөөд ийм ажилд төлбөр хийгдэхгүй.
- 5.29. Зөвлөх нь барилгын ажлын явцын тайланг сар бүр гарган Эрх бүхий этгээдэд ирүүлэх үүргийг хүлээнэ. Тайланд ажлын явц, ажлын явцад гарсан аливаа өөрчлөлтийн асуудал, цаашид авах арга хэмжээний талаар холбогдох фото зураг, график, тооцооны хамт танилцуулж байна. Барилгын ажил дууссаны дараа Зөвлөх нь төгсгөлийн тайлан бичиж Эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.
- 5.30. Гүйцэтгэгч гэрээний заалтуудыг зөрчиж, гэрээт хугацаандаа ажлаа дуусгаагүй бол Зөвлөх нь гэрээний зохих заалтын дагуу гэрээний торгууль ногдуулах санал гаргаж Эрх бүхий этгээдэд танилцуулах үүрэгтэй бөгөөд торгууль ногдуулах асуудлыг Эрх бүхий этгээд шийдвэрлэн Зөвлөхөд мэдэгдэнэ.
- 5.31. Гүйцэтгэгч гэрээт хугацаандаа ажлаа дуусгаж чадахгүй, ажлыг чанартай хийж гүйцэтгэх чадваргүй зэрэг асуудал тодорхой болсон нөхцөлд Зөвлөх нь гүйцэтгэгчийн гэрээг цуцлан өөр Гүйцэтгэгч сонгох, туслан гүйцэтгэгч авах зэрэг саналаа Эрх бүхий этгээдэд танилцуулна. Гэрээ цуцлах, өөр гүйцэтгэгч сонгох, туслан гүйцэтгэгч нэмж авах асуудлыг Эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.

- 5.32. Гүйцэтгэгч байгууллага ажлаа дуусгасны дараа Зөвлөх нь барилгын ажил дууссан тухай тайлан бичиж, Эрх бүхий этгээдэд хүргүүлж, барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссоор ажлаа хүлээлгэж өгнө.
- 5.33. Гүйцэтгэгчийн гэрээнд заасан баталгаат хугацаа дууссаны дараа Зөвлөх нь замын ашиглалтын байдлыг хянан үзэж, ажлын чанар муугаас болж гарсан эвдрэлийг Гүйцэтгэгчээр засуулан эцсийн тайлан бичиж барьцааны болон буцаах мөнгийг Гүйцэтгэгч байгууллагад эргүүлэн төлөх хүсэлтийг Эрх бүхий этгээдэд гаргана.
- 5.34. Баталгаат засварын хугацаа дуусах үед авто замын байдал болон Гүйцэтгэгчийн хийх шаардлагатай засварын ажлын талаар Эрх бүхий этгээдэд танилцуулна.
- 5.35. Барилгын ажил дууссаны дараа авто зам, замын байгууламжийг хүлээж авахад Эрх бүхий этгээдэд мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.
- 5.36. Зөвлөх нь Эрх бүхий этгээдтэй гэрээний болон чанарын баталгаат хугацааны турш байнгын харилцаатай байж бүх талын мэдээллээр хангана. Тайланг гэрээнд заасан хугацаанд нь боловсруулж гаргах ба эцсийн тайланг холбогдох засвар өөрчлөлтийг тусган эцсийн шатны тайлан, бүтээгдэхүүнийг (хэвлэмэл, pdf, docx, xlsx, dwg) боловсруулна.

#### **Зургаа. Зөвлөх үйлчилгээний Гүйцэтгэгчид тавигдах шаардлага**

- 6.1. Зөвлөх нь “Авто зам, замын байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, барих, арчлах, засварлах, техник, технологийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлын тусгай зөвшөөрөл олгох журам”-д заасан нөхцөл, шаардлагыг хангасан тусгай зөвшөөрөлтэй Монгол улсын хуулийн этгээд байна.
- 6.2. Зөвлөх нь Захиалагчийн тавьсан шаардлагыг хангасан бүрэлдэхүүнтэй хяналтын багийг томилж, ажлын талбайд байнга ажиллуулна. Зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан мэргэжилтнийг өөрчлөх шаардлага гарсан тохиолдолд Захиалагчтай зөвшилцөн, зөвшөөрөл авсны үндсэн дээр түүнтэй ижил түвшний мэдлэг боловсрол, туршлагатай хүнийг томилж ажиллуулна.
- 6.3. Хяналтын багийн ажилтнуудын амьдрах байр, тэдгээрийн тавилга, хэрэгсэл, компьютер, албан конторын бусад тоног төхөөрөмж, талбайд болон бусад этгээдтэй шуурхай холбоо барих хэрэгсэл, зам барилгын ажлын лаборатори, геодезийн багаж, хэрэгсэл, ажлын хээрийн хувцас, машин техник, гэх мэт ажил гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байх ба тээвэр, холбоо, цахилгаан, дулаан, бичиг хэрэг, ахуйн хангамж, зэрэг гарах зардлуудыг Зөвлөх өөрөө бүрэн хариуцна.

- 6.4. Хяналтын багийн ахлагч буюу Ерөнхий инженерээс бусад голлох мэргэжилтнүүд хэсгүүдэд зохион байгуулагдаж урьдчилан гаргасан ажлын хуваарийн дагуу барилгын ажлын талбайд байнга ажиллах шаардлагатай.
- 6.5. Зөвлөх нь ямар ч тохиолдолд захиалагчийн эрх ашгийг хамгаалан мэргэжлийн өндөр түвшинд хичээл зүтгэлтэй, үр дүнтэйгээр ажиллах ба гэрээт ажлын хэрэгжилтийн явцад гарах бүх зардлыг аль болох хамгийн бага хэмжээнд байлгах, төслийг чанартай хэрэгжүүлэх шаардлагатай бүх алхмыг хийж Захиалагчийн хүсэлтээр гэрээт ажилтай холбоотой бүх талын мэдээллийг гаргаж өгнө.
- 6.6. Зөвлөх үйлчилгээний байгууллага нь “Толгойтын авто замыг Ард Аюушийн өргөн чөлөөтэй холбох авто зам, гүүрэн байгууламж, олон түвшний огтлолцол” төслийн ажилд хяналт тавих 1 багийг ажиллуулах бөгөөд дор хаяж 12 голлох мэргэжилтнүүдтэй байх ба багт ажиллах ажилтны тоо үүгээр хязгаарлагдахгүй, гүйцэтгэгчийн ажлын зохион байгуулалт, онцлогоос шалтгаалан шаардлагатай үед голлох мэргэжилтэнгүүдийг нэмэгдүүлэн ээлжийн хуваарьт оруулан ажиллуулна. Голлох мэргэжилтнүүд нь дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

#### Хяналтын багийн голлох мэргэжилтнүүдэд тавигдах шаардлага

№	Албан тушаал	Тавигдах шаардлага	Хүний тоо
1	Ерөнхий инженер	<p>Ерөнхий инженер нь уг зөвлөх үйлчилгээг бүхэлд нь удирдан ажиллах бөгөөд зөвлөхийн ажлын үр дүнг Захиалагчийн өмнө бүрэн хариуцна.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Мэргэжлээрээ 10 жил, үүнээс 8-аас доошгүй жил зураг төслийн болон хяналтаар ажилласан байх,</li> <li>• Тэргүүн зэрэгтэй, зөвлөх инженер байх эсхүл ахлах инженерийн зэрэгтэй, мэргэшсэн инженер байх,</li> <li>• Удирдах ажлын туршлагатай байх, <i>/Зөвлөх инженер гэрээгээр байж болно/</i></li> </ul>	1
2	Авто замын инженер <i>/Хэсгийн ахлагч/</i>	<p>Хэсгийн ахлагч нь өөрийн хариуцаж буй хэсэг дэх зөвлөх багийн мэргэжилтнүүдийн ажлыг өдөр тутмын удирдлагаар ханган, ажлын талбайд байнга ажиллана.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Авто зам болон гүүрийн барилгын инженерийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,</li> <li>• Мэргэжлээрээ 10 жил, чиглэлээр 5 жил 3-аас доошгүй жил хяналтад ажилласан,</li> <li>• Ахлах инженерийн зэрэгтэй, мэргэшсэн инженер байх</li> </ul>	1
3	Авто замын инженер	<ul style="list-style-type: none"> <li>• Авто зам болон гүүрийн барилгын инженерийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,</li> <li>• Мэргэжлээрээ 10 жил, чиглэлээр 5 жил 3-аас доошгүй жил хяналтад ажилласан байх</li> </ul>	1

4	Гүүр, хиймэл байгууламжийн инженер	<ul style="list-style-type: none"> <li>Гүүрийн барилгын инженерийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,</li> <li>Гүүрийн барилгын чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил гүүрийн барилгын хяналтад ажилласан,</li> <li>Ахлах инженерийн зэрэгтэй, мэргэшсэн инженер байх</li> </ul>	1
5	Материалын инженер	<ul style="list-style-type: none"> <li>Авто замын барилгын инженер болон гүүрийн барилгын инженер эсвэл барилгын материалын инженерийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,</li> <li>Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил авто замын барилгын хяналтаар ажилласан, хяналтын ажлын туршлагатай байх,</li> <li>Хяналтын инженерийн итгэмжлэлтэй байх /Аль нэг инженер гэрээт байж болно/</li> </ul>	2
6	Ажлын тоо хэмжээний инженер	<ul style="list-style-type: none"> <li>Авто зам болон гүүрийн барилгын инженерийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,</li> <li>Авто зам, гүүрийн мэргэшсэн төсөвчин болон түүнээс дээш зэрэгтэй байх,</li> <li>Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил зураг хяналтаар ажилласан ажлын туршлагатай, зам, гүүрийн ажлын зургийн дагуу тоо хэмжээг бодож шалгах нягтлах туршлагатай байх</li> </ul>	1
7	Хэмжилтийн Инженер (геодезийн инженер)	<ul style="list-style-type: none"> <li>Авто зам болон гүүрийн барилга эсвэл геодезийн инженерийн мэргэжилтэй инженерийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,</li> <li>Тухайн чиглэлээр 5 жил, үүнээс 3-аас доошгүй жил авто замын барилгын хяналтад ажилласан, хяналтын ажлын туршлагатай,</li> <li>Хяналтын инженерийн итгэмжлэлтэй байх /Аль нэг инженер гэрээт байж болно/</li> </ul>	2
8	Инженерийн шугам сүлжээ хариуцсан инженер	<ul style="list-style-type: none"> <li>Цахилгаан, холбоо, дулаан, цэвэр, эсвэл бохир ус (гидрологич) чиглэлээр 10-оос доошгүй жил, үүнээс 3-аас доошгүй жил хяналтаар ажилласан, мэргэжлийн дагуу зураг төсөл болон барилгын ажил гүйцэтгэж байсан туршлагатай, мэргэшсэн зэрэгтэй байх. /Гэрээт байж болно/.</li> </ul>	1
9	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> <li>Байгаль орчны хамгаалал, хяналт, шинжилгээ, үнэлгээ, нөхөн сэргээлтийн аль нэг эсвэл тэдгээртэй адилтгах мэргэжлийн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй,</li> <li>Байгаль орчны хамгаалал, нөхөн сэргээлтийн чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан байх. /Гэрээт байж болно/.</li> </ul>	1
10	ХАБЭА-ийн мэргэжилтэн	<ul style="list-style-type: none"> <li>Мэргэжил харгалзахгүй бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй байх,</li> <li>ХАБЭА-н тусгай эрх бүхий сургалтын үнэмлэхтэй байх,</li> <li>Авто замын эсхүл барилгын салбарт ХАБЭА-н чиглэлээр 1-ээс дээш жил ажилласан байх. /Гэрээт байж болно/.</li> </ul>	1
		Нийт	12

6.7. Зөвлөх нь ажлыг шуурхай хянах, Гүйцэтгэгчийн ажлыг саатуулахгүй байх үүднээс Зөвлөх нь 5-аас багагүй хүний багтаамж бүхий 3-аас доошгүй авто машинтай байна. Зөвлөх нь компьютер, тоног төхөөрөмж, программ хангамж,

нивелир, теодолит, гэх мэт геодезийн хэмжилтийн багаж, хайгуулын ажлын машин, Стандарт норм дүрэм, төсвийн норм үнэлгээ, төсөв зохиох программ хангамжтай байх,

- 6.8. Зөвлөх үйлчилгээнд ашиглагдах хээрийн иж бүрэн лабораторитой байх эсхүл гэрээт лабораторитой байна.

### Долоо. Тайлангийн хуваарь

- 7.1. **Эхлэлийн тайлан:** Зөвлөх үйлчилгээний ажил эхэлснээс хойш 1 сарын дотор Захиалагчид хүргүүлнэ.
- 7.2. **Сар, улирал тутмын явцын тайлан:** Зөвлөх нь барилгын ажлын явцын тайланг сар бүр, улирал тутам гарган Захиалагчид ирүүлнэ. Тайланд барилгын ажлын явц, чанар байдал, ажлын явцад гарсан аливаа өөрчлөлтийн талаар, цаашид авах арга хэмжээний талаар холбогдох фото зураг, график, тооцооны хамт танилцуулна.
- 7.3. **Гүйцэтгэлийн тайлан:** Зөвлөх нь авто замын барилгын ажил дууссаны дараа гүйцэтгэлийн тайлан бичиж Захиалагчид хүргүүлнэ.
- 7.4. **Төслийн эцсийн тайлан:** Барилгын ажлын баталгаат хугацаа дуусгавар болсноор авто замын барилгын ажилд хяналт тавих зөвлөх үйлчилгээ дуусгавар болсонд тооцон төслийн эцсийн тайлан бичиж Захиалагчид хүлээлгэн өгнө.

### ХЯНАСАН:

НЗХГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга



В.Мягмар

НЗХГ-ын Зам барилга, инженерийн байгууламжийн хяналтын хэлтсийн дарга



Т.Батбилэг


### БОЛОВСРУУЛСАН:

НЗХГ-ын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн



Ц.Батжаргал

НЗХГ-ын Зам барилга, инженерийн байгууламжийн хяналтын хэлтсийн мэргэжилтэн



Б.Жаргалдүүрэн

2024 оны 04 сарын 01-ны өдөр